

МЕНЕЖМЕНТЭД ТУЛГУУРЛАН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ БОЛОМЖ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

Г. Дэлгэрмаа, Б. Ариунзаяа
МУБИС, Архангайн Багшийн сургууль
g_delgermaa@msue.edu.mn

Хураангуй

Хичээлийн хөтөлбөр нь хичээл болон багшийг сонгоход хэрэглэхэд үндсэн зориулалтаас гадна хичээлийн стандартын биелэлт, түүний чанар, үр дүнд сургуулиас баталгаажуулалт хийх, оюутны мэдлэг, чадвар эзэмших үйл ажиллагаа, арга замыг хэрхэн тодорхойлсныг үнэлэх тулгуур баримт бичиг юм. (Монгол улсын боловсролын их сургууль дүрэм, журам, гэрээ маягууд, 2019) Хөтөлбөр гэдэг нь тавьж буй зорилго, үр дүнд хүрэхэд баримтлах стратегийг тусгасан баримт бичиг буюу хийх үйлийн төлөвлөгөө юм.

Менежментэд тулгуурлан хичээлийн хөтөлбөрүүдээ боловсруулан, хэрэгжүүлэх нь багшид сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хянах, үнэлгээ хийх үйл явцыг цогцоор нь шийдвэрлэх боломжийг олгох давуу талтай юм. Иймээс менежментийн процессуудад тулгуурлан хичээлийн хөтөлбөрөө боловсруулж, хэрэгжүүлэх, үнэлэх, ажлыг хийж байгаа эсэхийг тодруулахыг зорилго.

Түлхүүр үг: Хөтөлбөр, менежмент, төлөвлөлт, зохион байгуулалт, идэвхжүүлэлт, хяналт

Үндэслэл:

Монгол улсын Засгийн газрын 316-р тогтоолоор батлагдсан “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд Монгол улсын боловсролын их сургууль сургалт явуулах хөтөлбөрүүдийг багш боловсролын шинэчлэлийн бодлого, гадаадын багш бэлтгэдэг их дээд сургуулиудын түвшинд ойртуулан шинэчлэх, дэвшилтэт арга технологиудыг сургалтад нэвтрүүлэх үүднээс хичээлийн хөтөлбөрүүдийг шинэчилж байна. Үүнтэй уялдан багш бүр өөрийн зааж буй хичээлийн хөтөлбөрүүдийг оюутан-багшид “**мэдлэг, чадвар, хандлага**” төлөвшүүлэхэд чиглэгдсэн хэлбэрээр боловсруулах хэрэгцээ шаардлага урган гарсан.

Менежментэд тулгуурлан хичээлийн хөтөлбөрүүдээ боловсруулан, хэрэгжүүлэх нь багшид сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хянах, үнэлгээ хийх үйл явцыг цогцоор нь шийдвэрлэх боломжийг олгох давуу талтай юм.

Зорилго: Менежментэд тулгуурлан хөтөлбөр боловсруулах боломж, түүний хэрэгжилтийг судлах

Зорилт:

1. Хичээлийн хөтөлбөр ба менежментийн талаар эрдэмтэн судлаачдын хийсэн онол – арга зүй, судалгааны материалыг судалж харьцуулан жиших замаар дүн шинжилгээ хийх.

2. МУБИС-ийн Архангайн Багшийн сургуулийн 2016-2020 оны хичээлийн жилд хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдээс 30 хөтөлбөр түүвэрлэн авч контент анализ хийх

Үндсэн хэсэг

Багш, сургууль боловсролын тухай ярих бүр хөтөлбөр гэдэг ойлголтыг хэрэглэдэг. Хөтөлбөр бол боловсролын зүрх юм. Учир нь нэгд хөтөлбөр нь юу заах тухай асуудал, хоёрт бодол, үйлдэл, зорилгын нэгдэл юм. Хөтөлбөрийг судлаачид янз бүрийн үзэл бодлын үүднээс томъёолон тайлбарласнаас С. Орнстейн, Франсис, П. Хүнскис нар хөтөлбөрийн тодорхойлолт болон түүнийг тодорхойлоход баримжаалж буй үзэл хандлагыг дараах үндсэн таван ангилалд хуваасан байна. (Одмаа, 2019, х.49)

1. Хөтөлбөр гэдэг нь судлагдахууны цогц юм.
2. Хөтөлбөр гэдэг нь суралцагсдын эзэмших туршлагын нийлбэр цогц буй туршлагын нийлбэр юм.

3. Хөтөлбөр гэдэг нь субъектүүд болон процессуудын удирдах систем буюу энэ хүү системийг хэрэгжүүлэх субъектүүд болон процетуруудын систем юм.

4. Хөтөлбөр гэдэг нь тавьж буй зорилго, үр дүнд хүрэхэд баримтлах стратегийг тусгасан баримт бичиг буюу хийх үйлийн төлөвлөгөө юм.


Тайлер болон Таба нарын анх дэвшүүлсэн “хөтөлбөр бол төлөвлөгөө юм” гэсэн үзэл хандлагыг бихеворист болон системийн удирдлагыг судлаачид дэмжиж байдаг. Тухайлбал Ж. Гален, Сайлор нар “хөтөлбөр гэдэг нь боловсрох гэж байгаа хүнд зориулсан түүний сурах бүхий л боломжийг тусгасан төлөвлөгөө мөн” (Весли Нулл, 2014, х.43) үзсэн бол Валис, Бонди нар “Хөтөлбөр гэдэг нь ямар сурахуй нь чухал болохыг зорилтоор илэрхийлсэн сурахуйн төлөвлөгөө” (Даваа, 2017, х.78) гэж тодорхойлсноос харахад хөтөлбөр гэдэг нь сургалтыг явуулах үйл ажиллагааны төлөвлөлт юм. Сургалтын энэхүү төлөвлөлтийг боловсруулж зохион байгуулах субъект нь багш түүний багшлахуйн үйл юм.

Багшлахуйн үйл нь менежментийн аливаа төлөвлөгөөний нэгэн адилаар үйл ажиллагааны

нэгэн удирдамж болж тодорхой бус байдлыг урьдаас нимгэлэн эцсийн үр дүнг өсгөхөд чиглэгдэх хэрэгтэй.

Хөтөлбөрийн боловсруулах үйл явц нь нь төлөвлөх, зохион байгуулах, идэвхжүүлэх, хяналт, үнэлгээ гэсэн менежментийн үндсэн дээр тулгуурлагдан хийгдэх боломжтой. Менежментийн үндсэн процессын төлөвлөлтөд багш өөрийн зааж буй хичээлийн хөтөлбөрийг боловсруулж хөтөлбөрийн хороогоор батлуулах, зохион байгуулалтад боловсруулсан хөтөлбөрийг лекц, семинар, лаборатори, практик хэлбэрүүдээр оюутны хэрэгцээ сонирхол, мэдлэг чадварт тохирсон сургалтын хэрэглэгдэхүүн материал, арга ашиглан чанартай гүйцэтгэх үйл явц багтана. Энэ үйл явцад багшийн сурган хүмүүжүүлэх нөлөөлөл, заах арга, ур чадвар зэрэг нь манлайлал процесст хамаарагдах юм. Тухайн хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт нь явцын болон эцсийн үнэлгээгээр илрэн гарна.

Менежментийн үндсэн процесст багшийн үйл ажиллагааг буулгавал



Менежментэд үндэслэн багшлахуйн төлөвлөхдөө урт хугацааны, дунд хугацааны, богино хугацааны гэсэн цаг хугацааг баримжаалах шаардлагатай.

- Урт хугацааны төлөвлөгөө нь: “Хүүхэд бүрийг хөгжүүлэх чадвартай бүтээлч багш, боловсролын салбарын мэргэжилтэнг бэлтгэх” МУБИС-ийн эрхэм зорилгод уялдуулан оюутан багшид эзэмшүүлэх мэдлэг, чадвар хандлагын тогтолцоонд тулгуурлан төлөвлөх. (Мэргэжлийн хөтөлбөрт тусгагдана)
- Дунд хугацааны төлөвлөгөө нь: Тухайн хичээлээр оюутан багшид олгож буй мэдлэг, чадвар хандлагын тогтолцоонд тулгуурлан төлөвлөх. (Хичээлийн хөтөлбөрт тусгагдана.)
- Богино хугацааны төлөвлөгөө нь: Тухайн сэдвийн хүрээнд оюутан багшид олгох мэдлэг, чадвар, хандлагын тогтолцоонд тулгуурлан төлөвлөх. (Ээлжит хичээлийн хөтөлбөрт тусгагдана.)

Эдгээрээс дүгнэхэд багш нар дунд хугацааны болон богино хугацааны төлөвлөгөөг сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдийн хөтөлбөрүүдийг өөрсдөө боловсруулж хөтөлбөрийн дэд хороогоор батлуулснаар сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж

байгаа нь менежментийн үүднээс тэд үйлийн менежерүүд юм.

Нийт хөтөлбөрүүдэд менежментийн процессуудыг тулгуурлан дараах чиглэлээр анализыг хийсэн болно.

Төлөвлөлтийн процесст хамаарах: Хичээлийн зорилго, зорилт, гарах үр дүнг оновчтой тодорхойлсон, хэрэгжүүлэх алхмын төлөвлөлт, арга зүйн сонголт, хэрэглэгдэхүүн материалын сонголт гэх мэт зүйлд анализ хийлээ

Зохион байгуулах процесст: Хөтөлбөрт үнэлгээ хийсний дараа хөтөлбөрийн хэрэгжилтэд ажиглалт хийсэн.

Багшийн манлайллын процесст: Багш оюутны суралцах үйлийг удирдан чиглүүлэх, дэмжин туслах, үлгэрлэх байдалд ажиглалт хийсэн болно.

Үнэлгээний процесст: Боловсруулсан хөтөлбөрүүдийн үнэлгээ оюутны танин мэдэхүйн чадвар хөгжлийн түвшинд тохирсон мэдлэг, чадвар, хандлагыг бодиттой үнэлэх чиглэлд анализ хийсэн болно.

Судалгааны үр дүн

Судалгааг МУБИС-ийн Архангайн Багшийн сургуулийн 2016-2020 оны хичээлийн жилд хэрэгжсэн хөтөлбөрүүдээс шинээр болон шинэчлэн боловсруулсан 30 хөтөлбөрт анализ хийж, мөн хөтөлбөрийн хэрэгжилтэд ажиглалт явуулж судалгааг боловсрууллаа.

Багш нарын хөтөлбөр боловсруулахдаа төлөвлөлтийн процессыг хангалттай сайн хийж гүйцэтгэж байгаа нь боловсруулсан хөтөлбөрүүдээс харагдлаа. Энэ нь МУБИС-ийн хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд сургалтаас гарах үр дүн PLO, хичээл стандарт буюу CLO-г нэгтгэн гаргасан учир багш нар хөтөлбөр боловсруулах төлөвлөхөд илүү хялбар болсон байна. Мөн МУБИС-ийн Хөтөлбөрийн нэгдсэн хорооноос хичээлийн хөтөлбөр боловсруулах шаардлага, зөвлөмж, загвар ирүүлсэнтэй холбоотойгоор багш нарын хичээлийн хөтөлбөрийн төлөвлөлтийг тухайн загвар зөвлөмжийн дагуу хангалттай сайн хийсэн байна.

Багш нарын хөтөлбөрт анализ хийсний дараа тодорхой хичээлүүдийн хөтөлбөрүүдийн хэрэгжүүлэх буюу зохион байгуулалтын процесст ажиглалтын аргаар судалгааг явууллаа. Зохион байгуулалтын үйл ажиллагаа нь тодорхой төлөвлөлттэй байгаа учир зохион байгуулахад хялбар байгаа хэдий ч хөтөлбөрийг зохион байгуулах байдал нь багшийн төлөвлөлт, болон хэрэгжүүлж буй байдалтай холбоотой байна. Тухайлбал хичээлийн хөтөлбөрийг 2-3 жил удаа дараалан зааж буй багш нарын хувьд хэрэгжүүлэх алхам, оюутнуудыг хийх үйлийг удирдан чиглүүлэх, зөвлөн туслах, үлгэрлэх, арга зүйг сонгон хэрэгжүүлэх нь сайн байлаа. Харин хичээлийн хөтөлбөрийг эхний удаа боловсруулан хэрэгжүүлж байгаа багш нарын хувьд дараах дутагдалтай тал ажиглагдлаа. Үүнд:

- Зааж буй оюутны мэдлэг чадварын төвшин харилцан адилгүй байгаа нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багш хүндрэл учирч байна
- Багшийн сонгосон арга зүй тухайн хичээлийн агуулгад нийцэхгүй байх
- Багш боловсруулсан хөтөлбөрийн төлөвлөгөөний дагуу зохион байгуулахгүй байх /тухайн хөтөлбөрт тусгасан арга зүйг ашиглахгүй байх гэх мэт/
- Хэрэглэгдэхүүний сонголт хэрэглэх боломж нөхцөл бүрдээгүй байх
- Төлөвлөлтийн алхмын хэрэгжих хугацаа зөрөөтэй байх гэх мэт дутагдалтай талууд ажиглагдлаа

Багшийн манлайлал нь хичээлийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд оюутан багшийн бүтээлч үйл ажиллагааг дэмжсэн, тодорхой дасгал даалгаврыг гүйцэтгэх арга зүйд тусалсан, асуудал хөндөж хамтран шийдвэрлэж байгаа нь менежментийн манлайллын процессыг амжилттай хэрэгжүүлж байна. Манлайллын процесс нь багшийн заах арга барил, сурган хүмүүжүүлэх эв дүүтэй шууд холбоотой юм.

Үнэлгээний процесс нь МУБИС-ийн Хөтөлбөрийн хорооноос ирүүлсэн “Үнэлгээний даалгаврын сан бүрдүүлэх” зөвлөмжийн дагуу багш бүр өөрийн боловсруулсан хөтөлбөрт явцын болон эцсийн үнэлгээ бие даалтын үнэлгээг хичээлийн стандартад заасны дагуу боловсруулан хэрэгжүүлсэн байна. Үнэлгээнд дараах чиглэлээр анализ хийсэн болно.

- Сорил дасгал даалгаврыг танин мэдэхүйн чадвар хөгжлийн түвшинд тус бүрээр боловсруулсан
- Сорил болон тестийн боловсруулалт иж бүрэн байдал
- Гүйцэтгэлд суурилсан үнэлгээний хэмжих шалгууртай
- Хичээлийн хүрэх үр дүнд баримжаалсан эсэх
- Сурагчдын бүтээлч үйл ажиллагааг дэмжсэн эсэх гэх мэт шалгуурын дагуу анализ хийлээ.

Багш нар хөтөлбөр боловсруулахдаа үнэлгээ тодорхой, оюутны танин мэдэхүйн түвшин түвшин тус бүрээр боловсруулан хэрэгжүүлэх байгаа нь сайшаалтай. Үнэлгээнд оюутны танин мэдэхүйн түвшин бүрээр тест ба цахим тестийг иж бүрэн боловсруулсан сургалтад ашигласан байна. Мөн уламжлалт арга аман болон бичгийн шалгалт хэлбэрийг хувилбарыг ашиглан хөтөлбөрийг боловсруулсан байна. Бие даалт оюутан-багшийн чадварт чиглэсэн гүйцэтгэлд суурилан тодорхой шалгууртайгаар, оюутны бүтээлч үйлийг дэмжин олон хувилбартайгаар хөтөлбөрт боловсруулан тусгасан байна. Гэвч тухайн хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлага буюу хичээлийн үр дүнг CLO-г үнэлэхдээ багш нар мэдлэг, чадварыг үнэлэх үнэлгээг боловсруулан хандлагыг үнэлэх үнэлгээг боловсруулаагүй байгаа нь задлан шинжилгээ хийх явцад харагдлаа

Хэлэлцүүлэг

Эрдэмтэн судлаачид хичээлийн хөтөлбөрийн талаар хэд хэдэн чиглэлээр судалгаа хийсэн байдаг бөгөөд бидний судалгаа нь менежментийн процессуудад тулгуурлан хөтөлбөр боловсруулах боломжийг судалснаараа онцлогтой юм.

ШУТИС-ийн дэд профессор Д.Одмаа “Улс төр судлалын сургалтын хөтөлбөрийг шинэчлэх судалгаа, үр дүн (Монголын их дээд сургуулийн жишээн дээр)” гэсэн нэг сэдэв бүтээлт улс төр судлалын хөтөлбөрийн шинэчлэлийг талаар авч үзсэн бол МУБИС-ын багш Д.Алтанзул “Сургалтын хөтөлбөр төлөвлөлтийг хэрхэн хийх вэ?” гэсэн илтгэлд хөтөлбөрийн загварчлалыг боловсруулах талаар авч үзсэн байгаагаараа ялгаатай байна.

Цаашид багш хичээлийн хөтөлбөрийн менежментэд тулгуурлан хичээлийн хөтөлбөрүүдээ боловсруулан, хэрэгжүүлэх нь багшид сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хянах, үнэлгээ хийх үйл явцыг цогцоор нь шийдвэрлэх боломжийг олгох давуу талтайг тус судалгаа харуулж байна.

Дүгнэлт

Менежментэд тулгуурлан хичээлийн хөтөлбөрүүдээ боловсруулан, хэрэгжүүлэх нь багшид сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хянах, үнэлгээ хийх үйл явцыг цогцоор нь шийдвэрлэх боломжийг олгох давуу талтай юм. Ингэснээр багшийн боловсруулсан хичээлийн хөтөлбөр нь бүрэн хэрэгжих боломжтой.

- Багш нарын хичээлийн хөтөлбөрүүдээ боловсруулахдаа төлөвлөлтийн хангалттай сайн хийж гүйцэтгэж байгаа нь боловсруулсан хөтөлбөрүүдээс харагдлаа.
- Төлөвлөсөн хичээлийн хөтөлбөрөө зохион байгуулалтын үйл ажиллагаанд шилжүүлэхэд оюутан – багшийн мэдлэг, чадварын төвшин харилцан адилгүй байх, багш нарын арга зүйн сонголт буруу зэрэг шалтгаанаас хамаарч хөтөлбөр дээр төлөвлөсөн хичээлийн зарим алхам буюу үе шатууд хэрэгжихэд хүндрэл учирч байна.
- Олонх багш нар оюутантай хамтарч ажиллах, тэдний бүтээлч үйлийг дэмжих арга зүйг түгээмэл ажиглаж байгаа нь манлайллын процесс сайн хэрэгжиж байгаагийн илрэл юм.
- Харин үнэлгээний процесст оюутан-багшийн мэдлэг чадварыг үнэлэх шалгууруудыг боловсруулж хэрэглэж байгаа боловч хандлагыг үнэлэх үнэлгээний шалгуур боловсруулахад хүндрэлтэй байгаа нь харагдаж байна.

Abstract:

Mongolian Government approved Resolution No. 316 "Pre-school and Primary and Secondary education teacher training and professional development of national programs" within the Mongolian State University of Education teacher training programs, educational reform, and university levels close update prepared by foreign teachers and the program has been organized to update the work from the 2015-2020 school year to introduce advanced training technologies. In line with its progress in every school programs to teach teachers need to develop forms designed to develop the student-teacher "of knowledge, skills and attitudes" requirement.

Reform program was formulated on the basis of planning, organizing and activation, monitoring and evaluation of management basis. Therefore, aimed at clarifying the challenges facing the implementation of development curricula on the management of teachers to develop and implement programs basis. Level of the programs vary management lesson plans reflect management oyuutan-teacher knowledge transfer in the development and qualification program to develop on the basis and method of selection of teachers incorrect and incomplete, as varied, depending being investigated academic stages scheduled on the program, including the planned change is difficult. Moreover, the criteria used for student teachers develop skills to assess knowledge, but appears to have difficulty developing approach to the assessment criteria.

Зохиогчийн тухай

Галбадрахын Дэлгэрмаа – 2004 онд МУБИС-ийг сэтгэл судлаач, багш мэргэжлээр төгссөн, сэтгэл судлалын магистр. 2004 оноос хойш МУБИС-ийн Архангайн Багшийн сургуульд сэтгэл судлалын багшаар ажиллаж байна. Хүүхдийн хөгжил, төлөвшил асуудлыг судалгааныхаа ажлын чиглэл болгон ажилладаг.

Бямбасүрэнгийн Ариунзаяа – 2007 онд МУИС-ийг сэтгэл судлаач, багш мэргэжлээр төгссөн, сэтгэл судлалын магистр. 2009 оноос хойш МУБИС-ийн Архангайн Багшийн сургуульд сэтгэл судлалын багшаар ажиллаж байна. Бага насны хүүхдийн сэтгэл судлалаар судалгааныхаа ажлын чиглэл болгон ажилладаг.

Ном зүй

Батсуурь. Н., (2009) Сургалтын хөтөлбөрийн хөгжил. Улаанбаатар.

Бадарч. Д., нар (2019) Суралцахуйн дизайн., Улаанбаатар

Весли Нулл., (2014) Киррикулум хөтөлбөр. Улаанбаатар.

Даваа.Ж., (2017) Сурган хүмүүжүүлэх зүй. Улаанбаатар.

Намжилдагва, Р., (2014) Суралцахуй хийгээд суралцахуйн онол, загварчлал. Улаанбаатар

Одмаа, Д., (2019) Сургалтын хөтөлбөр боловсруулах онол, арга зүй. Улаанбаатар

Пүрэвдорж. Ч., (2010) Багшлахуйн менежмент., Улаанбаатар